



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 09 ёдөр

Дугаар 1689

Улаанбаатар хот

Г

Г

Дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх
зөвшөөрлийн бичигний талаар авах зарим
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12 дахь заалт, Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 2 дугаар хавсралтын 1 дүгээр зүйл, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 222 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийн үнийг нэгдүгээр хавсралтаар тогтоосугай.
2. Дамжин өнгөрөх тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг тогтоосон үнээр аж ахуйн нэгж, байгууллагуудад олгохыг Тээвэр зохицуулалтын хэлтэс /Г.Доржпалам/, Санхүү, эдийн засгийн хэлтэс /Я.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд захирал /Б.Мөнхгарьд/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Б.ГУРСОРОНЗОН



“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын
2019 оны 09 дугаар сарын 9 ны өдрийн
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХЭД
АШИГЛАГДАХ ЗӨВШӨӨРЛИЙН БИЧГИЙН ҮНЭ

1. Дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэхэд ашиглагдах олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг - 22000 төгрөг

.....ооо.....